



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 01276

Улаанбаатар хот

「 Хан-Уул дүүргийн 26 дугаар сургуулийн 「
эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 98,761,755.0 /ерэн найман сая долоон зуун жаран нэгэн мянга долоон зуун тавин таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 26 дугаар сургууль /Д.Энхтайван/-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 87,298,200.0 /наян долоон сая хоёр зуун ерэн найман мянга хоёр зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 3 нэр төрлийн нийт 11,463,555.0 /арван нэгэн сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун тавин таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 26 дугаар сургууль /Д.Энхтайван/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

1150-000066

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн
0005 тоот тушаалын хавсралт

Хөрөнгө данснаас хасах тухай

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 26 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨАУГ-н шийдвэр
нийтийн эзэмшил											
1	хатуу хучилттай талбай	2	м2	1398	2,400	3,355,200.00	279,600.00	3,075,600.00	хуучирсан шинээр талбай хийх болсон	актлах	устгах
2	биеийн тамирын талбайн хайс	2	м2	973.3	2,850	2,773,905.00	138,695.25	2,635,209.75	хуучирсан	актлах	татах
3	төмөр хашаа 2*1	56	м2	321.3	18,500	5,944,050.00	5,944,050.00	-	хуучирсан шинэ хашаа хийх болсон	актлах	татах
4	төмөр хашаа	2	м2	124.8	22,000	2,745,600.00	137,280.00	2,608,320.00	хуучирсан шинэ хашаа хийх болсон	актлах	татах
5	сагсны талбай	2	ш	1	400,000	400,000.0	33,333.30	366,666.70	хуучирсан	актлах	устгах
6	тоглоомын талбай	2	м2	162	50,000	8,100,000.0	506,250.00	7,593,750.00	шинээр хөл бөмбөгийн талбай баригдсан	актлах	устгах

7	биеийн тамирын талбай	2	м2	2812	20,000	56,240,000.0	4,686,666.60	51,553,333.40	спорт заал баригдсан	актлах	устгах
8	авто зам	2	м2	519	37,000	19,203,000.0	1,200,187.50	18,002,812.50	спорт заал баригдсан	актлах	устгах
Нийтийн эзэмшлийн дүн						98,761,755.0	12,926,062.65	85,835,692.35			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						98,761,755.0	12,926,062.65	85,835,692.35			
Үүнээс татан төвлөрүүлэх хөрөнгө						11,463,555.00					
Актлах хөрөнгө						87,298,200.0					